

"МОНОС ХҮНС" ХК-ИЙН ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН /маягт 1/

<p>Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.</p>	
Тайлагнах хугацаа	2024 оны 01 дүгээр сарын 01 өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 31 өдрийг хүртэл
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	"МОНОС ХҮНС" ХК /МFC/ улсын бүртгэлийн дугаар 9010002005, регистрийн дугаар 5568927, утасны дугаар 7777-3525
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын хөрөнгийн бирж
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Хүнсний үйлдвэр
Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-д бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо	Онч аудит ХХК /2013-02-06/
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	408,850,429
Жилийн тайланг бэлтгэсэн, хянасан албан тушаалтны нэр	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Н.Цагаанхүү, Гүйцэтгэх захирал А.Отгондарь
1	Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/
	Санхүүгийн байдлын үзүүлэлт
	Тайланг цаасаар хэвлэн, тамгаар баталгаажуулан хавсаргав
	Орлогын тайлан
	Тайланг цаасаар хэвлэн, тамгаар баталгаажуулан хавсаргав
	Өмчийн өөрчлөлтийн тайлан
	Тайланг цаасаар хэвлэн, тамгаар баталгаажуулан хавсаргав
	Мөнгөн гүйлгээний тайлан
	Тайланг цаасаар хэвлэн, тамгаар баталгаажуулан хавсаргав
1.1.	Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт
	Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Аудит, эрсдэлийн хорооны 2025-02-14, 2025-03-26-ны өдрийн хурлаар компанийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлан, орлого үр дүнгийн тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон хөндлөнгийн аудитын компани "Онч аудит" ХХК-ийн дүгнэлт зэрэгтэй танилцан хэлэлцсэн. Дээрх санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт зэрэг нь олон улсын стандарт, нягтлан бодох бүртгэл, аудитын холбогдох хууль тогтоомж, дүрэм, эрх бүхий байгууллагаас гаргасан зохицуулалтын журмын заалтын дагуу үнэн зөв илэрхийлж тайлагнасан болохыг хорооны гишүүд санал нэгтгэйгээр дүгнэн, дүгнэлтийг хүлээн зөвшөөрч 2025-04-09 өдөр хуралдахаар товлогдоод байгаа Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахаар шийдвэрлэсэн.
1.2.	Аудитын тодорхойлох захидал /тодорхойлох захидлыг энэхүү зааварт дурдсан агуулгын хүрээнд боловруулсан байх/



	Компанийн 2024 оны санхүүгийн тайланд хөндлөнгийн аудитыг Онч аудит ХХК хийсэн бөгөөд түүний дүгнэлтэд "Монос хүнс ХК-ийн 2024 оны 12-р сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, мөнгөн гүйлгээний компанийн санхүүгийн байдлын тайлан, 2024 оны жилийн эцсийн ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлангууд, нягтлан бодох бүртгэлийн томоохон бодлогын хураангуйг агуулсан санхүүгийн тайлангийн тэмдэглэлүүд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал, санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаараа Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт ("СТОУС")-ийн дагуу үнэн зөв илэрхийлсэн байна гэж тодорхойлсон.	
2	Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл	
2.1.	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/	Борлуулалтын орлого өссөн дүнгээр өнгөрсөн оноос 20%-ийн өсөлттэй. Шингэн хүнсний бүтээгдэхүүний борлуулалт голлох нөлөөг үзүүлэв. Цэвэр ашгийн хэмжээ өнгөрсөн оноос 16% өсч ашгийн маржин 10.7%-тай байсан. Өөрийн хөрөнгийн өгөөж 17.2%-тай.
2.2.	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт	Эргэлтийн харьцаа: 0.91% Түргэн хөрвөх чадвар: 0.5%
2.3.	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл	Шингэн хүнсний үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, хуурай болон шингэн хүнсний үйлдвэрийг нэг байршилд нэгтгэх зорилгоор МФС 2.0 төслийг ажилттай 100%-н гүйцэтгэлтэй дуусгалаа. 2024 онд Экос брэнд эх дэлхийдээ илүү ээлтэй болж савлагаагаа шинэчлэн хуванцрын хэмжээгээ 30% бууруулсан.
2.4.	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээ байхгүй болно.
2.5.	Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл	Тайлант хугацаанд зээлийн бүх эргэн төлөлтүүд хугацаандаа хийгдсэн. Авсан зээлийн дүн: 18.4 тэрбум Төлсөн зээлийн дүн: 38.4 тэрбум
3	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол, зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/	
	2024 онд Компанийн тухай хуулийн 87 дугаар зүйлд заасан их хэмжээний хэлцэл хийгдээгүй, мөн хуулийн 89 дүгээр зүйлд заасан сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгосон шийдвэрийг 2024-06-27-ны өдрийн 07 тоот тогтоолоор гаргасан байна. Уг тогтоолоор Монос хүнс ХК-ийн хамааралтай компани болох "Эм Эн Эс Жи" ХХК-ийн эзэмшлийн Сонгинохайрхан дүүргийн 20-р хороо Сонсголонгийн зам дагуу байрлах, нэгж талбарын 1801500464 дугаартай 4 газраас 1.5 га талбайтай газрыг 1,4 тэрбум төгрөгөөр үнэлэн "Монос хүнс" ХК-ийн агуулах барих зориулалтаар худалдан авахыг зөвшөөрч, компанийг толоолон гэрээ хэлцэл хийх эрхийг гүйцэтгэх удирдлагад өгсөн шийдвэрийг уг хэлцэлд хамааралгүй, сонирхлын зөрчилгүй ТУЗ-ийн хараат бус гишүүдийн гарын үсгээр баталгаажуулсан. Хэлцлийн ач холбогдлын тухайд: Монос хүнс ХК нь хүнсний үйлдвэр, эрүүл мэндийн "Экос" ус, "Цэнэг" бэлдмэл, "Витос" шот зэрэг брэндийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг бөгөөд үйлдвэрлэдэг бүтээгдэхүүн овор хэмжээ их тул агуулах их шаарддаг, компанийн төв оффис болон 2 үйлдвэрт ойр байршилтай, мөн энэ байршлын газрын зах зээлийн үнийн доод үнээр худалдан авч байгаа гэсэн давуу нөхцлүүдийг харгалзан хэлцэлд сонирхлын зөрчилгүй ТУЗ-ийн гишүүдийн 100%-ийн саналаар худалдан авалт хийх шийдвэрийг гаргаж тогтоолд гишүүдээр баталгаажуулан гарын үсгийг зуруулсан.	

УЛААН
МОН
УЛСЫН
ХУУЛЬ

4	Цалин урамшууллын мэдээлэл
	<p>Компанийн дүрэмд ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тодорхойлох, урамшуулал олгох саналыг боловсруулах бүрэн эрхийг ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшууллын хороо хариуцаж байхаар тусгасны дагуу хорооноос саналыг боловсруулж Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэдэг. ТУЗ-ийн гишүүдийн цалин улирал бүр олгох /ээлжит хурлын/ тогтмол цалин болон ээлжит бус хурлын оролцоонд үндэслэсэн цалин гэсэн бүтэцтэй. Компанийн гүйцэтгэх захирал, удирдлагын багийн гишүүдийг хөдөлмөрийн гэрээ, онцгой нөхцөлт хөдөлмөрийн гэрээнд тусгасан дүнгээр үндсэн цалин, гүйцэтгэлээс хамаарсан урамшууллын цалин гэсэн үзүүлэлтээр дүгнэж байна. Компани 2024 онд нийт 9,7 тэрбум төгрөгийн цалин урамшууллыг ажилтнуудад олгосон, үүнээс 368 сая төгрөгийн цалин урамшууллыг ТУЗ, гүйцэтгэх захирал, санхүү хариуцсан захирал зэрэг эрх бүхий албан тушаалтанд олгосон байна.</p>
5	Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл
	<p>1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын талаар: 2024-04-20 өдөр Монос хүнс ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг танхим, цахим хосолсон хэлбэрээр зохион байгуулж, хуралд саналын эрхтэй 305 сая ширхэг хувьцаа буюу 74.84%-ийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид оролцон, компанийн 2023 оны санхүү, үйл ажиллагааны тайлан, хөндлөнгийн аудитын дүгнэлт зэрэгтэй танилцан, ТУЗ-ийн 2024 оны төсөв, компанийн дүрмийн нэмэлт өөрчлөлт, компанийн санхүү үйл ажиллагааны тайланд ТУЗ-өөс огсон дүгнэлт зэргийг хэлэлцүүлэн батлаж шийдвэрлүүлсэн. Хурлыг ТУЗ-ийн дарга Х.Ананд даргалж, ТУЗ-ийн гишүүд хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэн хуралдаа биеэр хүрэлцэн ирж, хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн асуултанд хариулж, хурлаа амжилттай зохион байгууллаа. Хурлын шийдвэр тэмдэглэл холбогдох баримт бичгийг хуулийн хугацаанд зохицуулагч байгууллагууд руу хүргүүлэн хянуулсан.</p> <p>2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын талаар: 2024-04-20-ны өдрийн 03 тоот тогтоолоор батлагдсан Монос хүнс ХК-ийн дүрмийн нэмэлт өөрчлөлтөд ТУЗ-ийн гишүүд 11 байхаар тусгасан учир хэрэгжилтийг хангахаар ТУЗ-ийн 2024-07-26-ны өдрийн 24/10 тоот тогтоолоор Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг цахимаар хуралдуулахаар зарлаж, хурлаар ТУЗ-ийн гишүүдийг сонгох асуудлыг хэлэлцсэн. Хуралд саналын эрхтэй 341 сая ширхэг хувьцаа буюу 83.58%-ийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид бүртгүүлэн оролцож, хурлын үеэр ТУЗ-ийн хараат болон хараат бус гишүүнд нэр дэвшигчдийн дэлгэрэнгүй танилцуулгыг мэдээлж, кумулятив аргаар цахим санал хураалтыг амжилттай зохион байгуулсан. Санал хураалтаар хуучин ТУЗ бүрэлдэхүүнд ажиллаж байсан хараат 6 гишүүн улиран сонгогдож, хараат бус 5 гишүүнийг шинээр сонгосон. Хурлыг Х.Ананд даргалж, хурлын шийдвэр тэмдэглэлийг хуулийн хугацаанд зохицуулагч байгууллагууд руу хүргүүлсэн.</p> <p>3.Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 онд хийсэн ажлын талаар: Дээрх ХЭЭХ-аас гарсан тогтоолын хэрэгжилтийг хангах үүднээс ТУЗ-ийн хараат бус гишүүдийн сонгон шалгаруулалтыг нээлттэйгээр зарлан 28 хүн анкет мэдээллээ ирүүлснээс ТУЗ-ийн дэргэдэх НДХ-оос 13 хүнийг сонгон шалгаруулж 2024-09-09 өдөр зарлан хуралдуулсан Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар ердийн 6, хараат бус 5, нийт 11 гишүүнийг сонгон ТУЗ-ийн бүрэлдэхүүн шинэчлэгдэн, анхны ТУЗХ-аа 2024-09-18 өдөр хуралдаж, ТУЗ-ийн дарга, хороодын дарга, гишүүд, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нарыг сонгон томилж ажиллаж эхэлсэн юм. ТУЗ-ийн дэргэд Аудит, эрсдэлийн хороо (АЭХ) 5 гишүүнтэй, даргаар хараат бус гишүүн Г.Золжаргал, Цалин урамшууллын хороо (ЦУХ) 3 гишүүнтэй, даргаар хараат гишүүн Х.Ананд, Нэр дэвшүүлэх хороо (НДХ) 3 гишүүнтэй, даргаар хараат бус гишүүн Д.Энхжаргал, Стратеги, бизнес хөгжлийн хороо (СБХХ) 5 гишүүнтэй, даргаар хараат бус гишүүн Д.Гэрэлт-Од нар сонгогдон ажиллаж байна. Хороодын гишүүдийн хувьд дийлэнх нь хараат бус гишүүд байх зарчмыг баримтлан сонгосон. Компанийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд зааснаар ТУЗ-ийн ээлжит хурал улиралд 1 удаа, ээлжит бус хурлыг хуульд заасны дагуу тухайн үед зарлан хуралдуулдаг. 2024 онд 2024-01-01 өдрөөс 2024-09-09 өдрийг хүртэл ТУЗ 9 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр, 2024-09-09 өдөр хуралдсан Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын өдрөөс хойш ТУЗ 11 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр ажилласан. 2024 онд ТУЗ нийт 10 удаа танхим, цахим, эчнээ санал хураалтын хэлбэрээр хуралдсанаас ээлжит хурал 4, ээлжит бус хурал 6 удаа хуралдаж, нийт 17 тогтоол гаргасан. КТХ, СЗХ-оос баталсан Компанийн засаглалын кодексын 2-р зарчимд заасан ТУЗ хараат бус гишүүдийн оролцоог нэмэгдүүлэх үүднээс хороодын даргыг хараат бус гишүүнээр сонгож, хороодын бүрэлдэхүүнийг дийлэнх хувийг хараат бус гишүүдээс бүрдүүлж, их хэмжээний хэлцэл, сонирхлын зөрчилтэй хэлцэл, хөрөнгө худалдах, худалдан авах, компанийн стратегийн шийдвэр гаргалт, эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал, томилгоо, сонгон шалгаруулалт зэрэг асуудлыг хорооны хурлаар заавал хэлэлцүүлж байж ТУЗ хуралд оруулан шийдвэрлүүлж байх, ингэснээрээ жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалсан шийдвэр гаргахад ТУЗ-ийн хараат бус гишүүдийн санал оролцоог голлож байхаар зохицуулалтын баримт бичгийг боловсруулан, томилгоо, бүрэлдэхүүнийг сонгоод байна. 2024 онд ТУЗ-ийн дэргэдэх АЭХ 4 удаа, СБХХ 2 удаа, НДХ 3 удаа, ЦУХ 1 удаа хуралдсан байна. Компани 2024 онд "Хүнсний манлай үйлдвэр" шагналыг хүртсэн юм.</p>

ЭХ
СААТ
ОС
ХК
55689
ЭХ



6	Зэх зээлийн эрсдэлийн мэдээлэл
	Байхгүй
7	Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/
	"Монос хүнс" ХК нь хүнсний үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, Монголын Хөрөнгийн Биржид нээлттэйгээр арилжаалагддаг нийт 408,850,428 ширхэг хувьцаатай, 2012 онд үүсгэн байгуулагдсан, үндэсний үйлдвэрлэгч компанийн нэг юм. Нийт хувьцааны 70% буюу 286,195,300 ширхэг хувьцааг Л.Хүрэлбаатар (эцсийн өмчлөгч), үлдсэн 30% буюу 122,655,128 ширхэг хувьцааг олон нийт эзэмшдэг. Компанийн тухай хууль болон компанийн дүрэмд зааснаар "Монос хүнс" ХК-ийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал бөгөөд ээлжит хурлыг жилдээ 1 удаа хуульд заасны дагуу хуралдуулдаг. Компанийн 2024 оны санхүү үйл ажиллагаа хэлэлцэх хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2025 оны 04 сарын 09 өдөр Баянгол дүүрэг, Сонсголонд байрлах өөрийн Эрүүл мэндийн хүнсний үйлдвэрийн байрандаа танхим, цахим хосолсон хэлбэрээр зохион байгуулсан. Хуралд нийт 408,850,428 ширхэг хувьцаанаас саналын эрхтэй 306,711,651 ширхэг хувьцаа буюу 75,02%-ийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид танхим, цахимаар оролцсон тул хурлыг хуульд заасан хүчин төгөлдөрт тооцож хуралдуулан, хурлаар хэлэлцэх асуудлуудыг шийдвэрлэж тогтоол шийдвэрийг гаргасан. Хурлаас гарсан шийдвэр болон хурлын үйл ажиллагаатай холбоотой баримт бичиг материалыг хуульд заасан хугацаанд Санхүүгийн Зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Биржид хүргүүлж ажилласан. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийг 2025-03-12 өдрөөр бүртгэхэд 15,462 хувьцаа эзэмшигчийн судалгааг ҮЦГХТ-оос гарган ирүүлсэн юм.
8	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл
	Тайланг өмнө тайлагнасан
9	Ногдол ашгийн мэдээлэл
	КТХ-ийн 76 дугаар зүйлийн 76.1.12 дахь заалтад заасан бүрэн эрхийн хүрээнд ТУЗ-ийн 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 25/02 тоот тогтоолоор компанийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгагдсан цэвэр ашгаас 37% буюу 1,635,401,712 төгрөг, нэгж хувьцаанд 4 төгрөгөөр тооцон ногдол ашиг тараах, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдрийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тасалбар болгон тогтоож, ногдол ашгийг "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ТӨХХК-иар дамжуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдөрт багтаан олгохоор шийдвэрлэсэн. Ногдол ашиг олгох мэдээллийг Монголын Хөрөнгийн Биржийн вэб хуудас, компанийн вэб хуудас, фэйсбүүк нэйж зэрэг цахим сувгуудад байршуулж, мэдээллийг түгээж байна.
10	Үнэт цаас гаргагчаас тайлант хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл
	<p>1. Хүн ардын эрүүл мэндийн төлөө, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч компанийн хувьд олон нийт, ард түмэн рүү чиглэсэн олон төрлийн арга хэмжээг зохион байгуулж, бусад байгууллага, компанитай хамтран ажиллаж, ард иргэдэд мэдлэг олгох сургалт, зөвлөгөө, өдөрлөг зэрэг олон хэлбэрээр нийгэмд эерэг нөлөө үзүүлэхээр тогтмол хийж далсан эмнэлэг, сувилал зэрэг эрүүл мэндийн байгууллагуудтай хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэн ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд "Эрүүл мэндийн өдөрлөг, арга хэмжээ"-г 6 сувиллаар амжилттай зохион байгуулж, нийт 1000 гаруй амрагч, ахмадуудыг хамарч нийгэмд тулгамдаад буй өвчлөл, түүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар эмч, мэргэжилтнүүдтэй хамтран зөвлөгөө өгсөн.</p> <p>2. Монгол Улсад анх удаа эмэгтэйчүүд, хүүхдүүдийн эсрэг үйлдэгдэж буй гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийг арилгах зорилгоор байгуулагдсан Хүчирхийллийн төвд байрлаж байгаа хүүхдүүдэд зориулан гарын бэлэг хандивлалаа. Энэ төвийн үйл ажиллагаа нь хохирогчдод эрх зүйн болон сэтгэлзүйн туслалцаа үзүүлэх, тэднийг хамгаалах, нийгэмд эерэг өөрчлөлт авчрахад чиглэгддэг бөгөөд "Монос Хүнс" ХК-ийн хамт олон энэхүү үйл ажиллагаанд хувь нэмэр оруулж буйгаа илэрхийлэн, цаашид ч тус төвтэй хамтран ажиллахад бэлэн гэдгээ мэдэгдлээ.</p> <p>3. Лантуун Дохио ТББ-ын хамт олонд "Аами" брэндийн гүзээлзгэнэтэй аньсны шүүс, чацарганатай үрэл зэрэг хүүхдийн эрүүл мэндийг дэмжих, дархлааг сайжруулах 4200 ширхэг бүтээгдэхүүнийг хандивлалаа. Монос хүнс ХК нь хүүхэд хамгаалал, түүний сайн сайхан байдлыг хангах, амьдралын чанарыг дээшлүүлэх чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй энэ байгууллагын хэрэгжүүлж буй төсөл, хотолборүүдийг дэмжиж, хүүхдийн эрх, эрүүл мэндийг хамгаалахад чиглэсэн хамтын ажиллагаагаа өргөжүүлэхээр хамтран ажиллаж байна.</p>

ХҮНИ
907500

4. Хэрэглэгчдэд эрүүл амьдралын хэв маягийг таниулах, хүүхэд залуусыг спортоор хичээллэх сэдлийг төрүүлэх зорилгоор "Экос" брэндийн бүтээгдэхүүнээр спортыг дэмжин ажилласаар ирсэн билээ. Энэ хүрээнд тайлант хугацаанд -Монголын сагсан бөмбөгийн холбооны Үндэсний дээд лигийн ВСН Knights багтай 3 дахь жилдээ хамтран ажиллаж байна. -Монголын чөлөөт бөхийн холбооноос эхлүүлсэн бөхийн хөгжил, баг тамирчдаа дэмжих аяны хүрээнд "Парис-2024" зуны XXXIII олимпын наадамд оролцох Монголын чөлөөт бөхийн баг тамирчдыг байгалийн хужраар эрдэсжүүлж, зөөлрүүлсэн, ходоодны хүчил саармагжуулж, цээж хорсолт намдаах үйлчилгээтэй "Экос" зөөлөн усаараа дэмжин, хандивын аянд нэгдсэн юм.

5. 2024 онд MFC 2.0 үйлдвэрлэлийг ашиглалтад оруулснаар "Экос" усны хуванцар савны хэмжээг 30%-аар бууруулж, илүү байгальд ээлтэй болсноор базаад хаяхад амархан болж дахин боловсруулах явцад хамгийн сайн задралд орох боломжтой болсон, мөн эрчим хүчний хэрэглээг 20%, цайны сав баглаа боодлын цаас болон уутны хэрэглээг 90% тус тус бууруулж, компанийн үйл ажиллагааг нэг дор төвлөрүүлснээр түүхий эд материал болон бэлэн бүтээгдэхүүн тээвэрлэх замын уртыг 11 дахин бууруулсан байна. Мөн үйлдвэрээс гарсан саарал усыг ахуйн хэрэглээ, гадна мод зүлэг услах, зам талбайн арчилгаанд бүрэн хэрэглэх зэргээр байгаль орчиндоо ээлтэй үйл ажиллагаа явуулахыг эрхэмлэн ажиллаж байна.

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Овог нэр: Агваандорж овогтой Отгондарь
Албан тушаал: "Монос хүнс" ХК-ийн Гүйцэтгэх захирал
Гарын үсэг:  (Тамга/гэмдэг)
Овог, нэр: Нацаг овогтой Цагаанхүү
Албан тушаал: "Монос хүнс" ХК-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга
Гарын үсэг: 



Сангийн сайдын 2012 оны
.....дүгээр тушаалын
.... дугаар хавсралт

Регистрийн дугаар:

5	5	6	8	9	2	7
---	---	---	---	---	---	---

Хаяг: Хан-Уул дүүрэг, Чингисийн өргөн чөлөө 205/2

Шуудангын хаяг:

Утас: 77773525

Факс: 11-343525

Өмчийн Хэлбэр: ХК

Төрийн ... Хувь

Хувийн хувь



**"МОНОС ХҮНС " ХК
2024 ОНЫ 4-Р УЛИРЛЫН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Хянаж хүлээн авсан байгууллагын нэр	Сар, өдөр	Гарын үсэг

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Монос хүнс ХК

(Аж ахуйн нэгжийн нэр)

2024

2023

1 ХӨРӨНГӨ**1.1 Эргэлтийн хөрөнгө**

1.1.1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	2,292,388,399.49	27,537,478,725.73
1.1.2 Дансны авлага	5,196,943,405.78	3,956,881,152.33
1.1.3 Татвар, НДШ - ийн авлага	43,712,058.17	2,174,902,729.74
Урьдчилж төлсөн татвар	43,712,058.17	2,174,902,729.74
Урьдчилж төлсөн даатгал	-	-
1.1.4 Бусад авлага	300,498,638.15	155,898,950.41
1.1.5 Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
1.1.6 Бараа материал	7,806,736,214.22	4,944,922,170.59
Бараа	2,028,188,244.61	1,085,059,770.83
Түүхий эд материал	4,091,924,630.88	3,230,096,097.33
Хангамжийн материал	546,241,317.94	431,434,616.73
Дуусаагүй үйлдвэрлэл	(0.00)	-
Агентад байгаа бараа	-	-
Замд яваа бараа	1,140,382,020.80	198,331,685.71
1.1.7 Урьдчилж төлсөн зардал/тооцоо	500,671,066.50	393,107,144.89
Урьдчилж төлсөн зардал	101,616,530.86	152,965,823.76
Урьдчилж төлсөн тооцоо	399,054,535.63	240,141,321.12
1.1.8 Бусад эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.9 Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	1,428,798,812.66	-
Нийт 1.1 Эргэлтийн хөрөнгө	17,569,748,594.98	39,163,190,873.69

1.2 Эргэлтийн бус хөрөнгө

1.2.1 Үндсэн хөрөнгө	38,045,043,212.68	37,399,888,885.06
1.2.2 Биет бус хөрөнгө	327,069,927.17	414,045,069.65
1.2.3 Биологийн хөрөнгө	-	-
1.2.4 Урт хугацаат хөрөнгө оруулалт	-	-
1.2.5 Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	-	-
1.2.6 Хойшлогдсон татварын хөрөнгө	95,157,299.38	76,129,571.34
1.2.7 Бусад эргэлтийн бус хөрөнгө	2,951,401,639.70	283,210,938.04
Нийт 1.2 Эргэлтийн бус хөрөнгө	41,418,672,078.93	38,173,274,464.09

Нийт 1 ХӨРӨНГӨ**58,988,420,673.91 77,336,465,337.78****2 ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ****Өр төлбөр**

2.1.1 Богино хугацаат өр төлбөр	19,392,905,710.12	19,484,477,030.52
2.1.2 Дансны өглөг	1,621,095,551.66	1,079,640,204.43
2.1.3 Цалингийн өглөг	604,991,316.78	164,472,880.00
2.1.4 Татварын өр	866,574,008.78	1,688,054,915.53
2.1.5 НДШ-ийн өглөг	84,383,678.00	151,542,740.16
2.1.6 Богино хугацаат зээл	14,625,080,000.00	15,184,920,000.00
2.1.7 Зээлийн хүүгийн өглөг	32,354,972.27	249,479,832.44
2.1.8 Ногдол ашгийн өглөг	-	-
2.1.9 Урьдчилж орсон орлого	93,651,258.52	48,499,204.42
2.1.10 Нөөц өр төлбөр	231,013,841.60	211,013,841.60

2.1.11 Бусад богино хугацаат өр төлбөр	1,233,761,082.51	706,853,411.93
2.1.12 Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө) - нд хамаарах өр төлбөр	-	-
2.1.13 Урт хугацаат өр төлбөр	16,041,972,026.56	35,845,809,142.09
2.1.14 Урт хугацаат зээл	13,507,431,878.28	29,025,579,664.00
2.1.15 Нөөц өр төлбөр	2,467,568,121.72	6,449,500,336.00
2.1.16 Хойшлогдсон татварын өр	-	213,517,809.29
2.1.17 Бусад урт хугацаат өр төлбөр	66,972,026.56	157,211,332.79
Нийт Өр төлбөр	35,434,877,736.68	55,330,286,172.61
Эздийн өмч		
2.1.1 Өмч - Төрийн	-	-
2.1.2 Өмч - Хувийн	-	-
2.1.3 Өмч - Хувьцаат	2,318,181,926.76	2,318,181,926.76
2.1.4 Халаасны хувьцаа	-	-
2.1.5 Нэмж төлөгдсөн капитал	6,835,733,063.19	6,835,733,063.19
2.1.6 Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	-	2,508,104,274.29
2.1.7 Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-
2.1.8 Эздийн өмчийн бусад хэсэг	-	-
2.1.9 Хуримтлагдсан ашиг	14,399,627,947.27	10,344,159,900.94
Нийт Эздийн өмч	23,553,542,937.22	22,006,179,165.17
Нийт 2 ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	58,988,420,673.91	77,336,465,337.78

4 Зөрүү

Гүйцэтгэх захирал



(А. Отгондарь)

Санхүү хариуцсан захирал

(Ц. Дэлгэрмаа)

ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Монос хүнс ХК

(Аж ахуйн нэгжийн нэр)

2024

2023

1 Орлого үр дүн

1.1 Борлуулалтын орлого (цэвэр)	37,993,253,987.23	31,676,949,027.58
1.2 Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	19,715,029,072.14	17,203,846,543.85
1.3 Нийт ашиг (алдагдал)	18,278,224,915.08	14,473,102,483.73
1.5 Хүүний орлого	150,461,648.37	11,025,158.14
1.6 Ногдол ашгийн орлого	-	-
1.7 Эрхийн шимтгэлийн орлого	-	-
1.8 Бусад орлого	66,054,081.10	35,530,930.13
1.9 Борлуулалт, маркетингийн зардал	8,303,161,562.16	6,711,229,370.61
1.10 Ерөнхий ба удирдлагын зардал	4,312,876,978.62	3,029,457,340.64
1.11 Санхүүгийн зардал	1,022,862,566.18	635,650,267.09
1.12 Бусад зардал	273,335,861.58	207,872,698.78
1.13 Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(37,172,653.45)	(18,070,006.42)
1.14 Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	17,183,444.11	-
1.15 Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
1.16 Хөрөнгө оруулалт борлуулсны олз (гарз)	-	-
1.17 Бусад ашиг (алдагдал)	-	-
1.18 Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	4,562,514,466.67	3,917,378,888.46
1.19 Орлогын албан татвар	511,814,045.34	437,088,692.03
1.20 Татварын дараах ашиг (алдагдал)	4,050,700,421.34	3,480,290,196.43
1.21 Зогсоосон үйл ажиллагааны татвар	-	-
1.22 Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	4,050,700,421.34	3,480,290,196.43
1.23 Бусад дэлгэрэнгүй орлого	(2,508,104,274.29)	2,097,189,789.65
Нийт 1 Орлого үр дүн	1,542,596,147.05	5,577,479,986.08

Гүйцэтгэх захирал

(А. Отгондарь)

Санхүү хариуцсан захирал

(Ц. Дэлгэрмаа)



ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Монос хүнс ХК
(Аж ахуйн нэгжийн нэр)2024 оны 12 сарын 31 өдөр
/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2023 оны 01 сарын 01-ний үлдэгдэл	2,318,181,926.76	0.00	6,835,733,063.19	410,914,484.64	0.00	0.00	7,725,833,099.36	17,290,662,573.94
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
3	Залруулсан үлдэгдэл	2,318,181,926.76	0.00	6,835,733,063.19	410,914,484.64	0.00	0.00	7,725,833,099.36	17,290,662,573.94
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	3,480,290,196.43	3,480,290,196.43
5	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
6	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
7	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	-981,241,027.20	-981,241,027.20
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	2,097,189,789.65	0.00	0.00	119,277,632.35	2,216,467,422.00
9	2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2,318,181,926.76	0.00	6,835,733,063.19	2,508,104,274.29	0.00	0.00	10,344,159,900.94	22,006,179,165.17
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	-392,324,281.78	0.00	0.00	566,740,914.39	174,416,632.61
11	Залруулсан үлдэгдэл	2,318,181,926.76	0.00	6,835,733,063.19	2,115,779,992.51	0.00	0.00	10,910,900,815.33	22,180,595,797.78
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	4,050,700,421.34	4,050,700,421.34
13	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	-2,677,753,281.90	0.00	0.00	0.00	-2,677,753,281.90
14	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
15	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	561,973,289.39	0.00	0.00	-561,973,289.39	0.00
17	2024 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2,318,181,926.76	0.00	6,835,733,063.19	0.00	0.00	0.00	14,399,627,947.27	23,553,542,937.22

Гүйцэтгэх захирал

Санхүү хариуцсан захирал



(А. Отгондарь)

(Ц. Дэлгэрмаа)

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Монос хүнс ХК

(Аж ахуйн нэгжийн нэр)

2024

2023

1 Бүх цэвэр мөнгөн гүйлгээ**1.1 Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ**

	2024	2023
1.1.1 Мөнгөн орлогын дүн (+)		
1.1.1.1 Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	39,978,166,590.08	34,015,031,813.20
1.1.1.2 Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
1.1.1.3 Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	3,221,688.60	4,616,680.48
1.1.1.4 Буцаан авсан албан татвар	201,491,963.40	-
1.1.1.5 Татаас, санхүүжилтийн орлого	-	-
1.1.1.6 Бусад мөнгөн орлого	216,546,132.26	13,860,764.51
Нийт 1.1.1 Мөнгөн орлогын дүн (+)	40,399,426,374.33	34,033,509,258.19
1.1.2 Мөнгөн зарлагын дүн (-)		
1.1.2.1 Ажиллагчдад төлсөн	(7,292,927,444.06)	(5,008,558,949.11)
1.1.2.2 Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	(2,411,892,628.14)	(1,705,388,907.54)
1.1.2.3 Бараа материал худалдан авахад төлсөн	(16,567,814,408.51)	(11,087,217,362.90)
1.1.2.4 Ашиглалтын зардалд төлсөн	(800,921,736.67)	(548,282,778.15)
1.1.2.5 Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	(890,687,331.52)	(662,376,574.74)
1.1.2.6 Хүүний төлбөрт төлсөн	(2,842,768,121.54)	(2,859,718,765.74)
1.1.2.7 Татварын байгууллагад төлсөн	(5,140,475,954.71)	(4,205,520,615.02)
1.1.2.8 Даатгалын төлбөрт төлсөн	(122,692,890.15)	(108,065,510.15)
1.1.2.9 Бусад мөнгөн зарлага	(5,565,660,651.16)	(4,457,261,510.69)
Нийт 1.1.2 Мөнгөн зарлагын дүн (-)	(41,636,041,166.48)	(30,642,390,974.04)
Нийт 1.1 Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	(1,236,614,792.15)	3,391,118,284.15

1.2 Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ

	2024	2023
1.2.1 Мөнгөн орлогын дүн (+)		
1.2.1.1 Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	775,640.00	3,780,000.00
1.2.1.2 Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
1.2.1.3 Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-
1.2.1.4 Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	-	-
1.2.1.5 Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	7,900,000.00	9,954,068.00
1.2.1.6 Хүлээн авсан хүүний орлого	-	-
1.2.1.7 Хүлээн авсан ногдол ашиг	-	-
Нийт 1.2.1 Мөнгөн орлогын дүн (+)	8,675,640.00	13,734,068.00
1.2.2 Мөнгөн зарлагын дүн (-)		
1.2.2.1 Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(3,900,745,076.57)	(10,620,045,027.54)
1.2.2.2 Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(4,300,000.00)	-
1.2.2.3 Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
1.2.2.4 Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
1.2.2.5 Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	(41,000,000.00)	(6,000,000.00)
Нийт 1.2.2 Мөнгөн зарлагын дүн (-)	(3,946,045,076.57)	(10,626,045,027.54)
Нийт 1.2 Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	(3,937,369,436.57)	(10,612,310,959.54)

1.3 Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ

	2024	2023
1.3.1 Мөнгөн орлогын дүн (+)		
1.3.1.1 Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	18,377,364,035.00	43,853,517,924.13

1.3.1.2 Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
1.3.1.3 Төрөл бүрийн хандив	18,377,364,035.00	43,853,517,924.13
Нийт 1.3.1 Мөнгөн орлогын дүн (+)		
1.3.2 Мөнгөн зарлагын дүн (-)		
1.3.2.1 Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	(38,437,284,035.00)	(8,449,607,190.30)
1.3.2.2 Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
1.3.2.3 Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	-	(930,688,455.24)
1.3.2.4 Төлсөн ногдол ашиг	(38,437,284,035.00)	(9,380,295,645.54)
Нийт 1.3.2 Мөнгөн зарлагын дүн (-)		
Нийт 1.3 Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	(20,059,920,000.00)	34,473,222,278.59
1.4 Валютын ханшийн зөрүү	(11,186,097.51)	(10,074,380.58)
Нийт 1 Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(25,245,090,326.23)	27,241,955,222.62
2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	27,537,478,725.73	295,523,503.11
3 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,292,388,399.49	27,537,478,725.73

Гүйцэтгэх захирал

Санхүү хариуцсан захирал



(А. Отгондарь)

(Ц. Дэлгэрмаа)

2024



ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

БИЗНЕСИЙН ФИЛОСОФИ

АЛСЫН ХАРАА



Эх дэлхийгээ хайрлаж,
Эрүүл амьдралыг хамтдаа бүтээнэ.

ЭРХЭМ ЗОРИЛГО



Хүрээлэн буй орчин, оролцогч талуудаа
хүндэлсэн, эрүүл амьдралын хэв маягийг
дэлгэрүүлэгч, үнэ цэн бүтээгч компани байна.

ҮНЭТ ЗҮЙЛ



Оролцогч
талууд

Эерэг соёл

Инновацлаг
бүтээгдэхүүн

АГУУЛГА

1. БИДНИЙ ТУХАЙ	
Гүйцэтгэх захирлын мэндчилгээ	5
Түүхэн товчоо	6
Удирдлагын баг	8
Хэрэгжүүлж буй стандартууд	9
2. ЭКСПОРТ	10
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАН	
Санхүүгийн тайлан мэдээ	14
Голлох үзүүлэлтүүд	18
4. 2024 ОНЫ ҮЙЛ ЯВДЛЫН ТОЙМ	
Онцлох үйл явдал	21
5. 2024 ОНЫ ТУЗ-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА	
ТУЗ-ийн даргын мэндчилгээ	24
Төлөөлөн Удирдах Зөвлөл	25
ТУЗ-ийн 2024 оны үйл ажиллагааны тайлан	26
6. ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТ	
Байгаль орчин, нийгэм, засаглал	29

1

БИДНИЙ ТУХАЙ



МОНОС ХҮНС ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ



Монос Хүнс ХК-ийн Гүйцэтгэх захирал
А.ОТГОНДАРЬ

Эрхэм хэрэглэгчид, хувьцаа эзэмшигчид, хамтран ажиллагсад та бүхэнд энэ өдрийн мэндийг дэвшүүлэе.

Манай компани 2024 оны жилийн эцсийн тайлангаа танилцуулж байгааг хүлээн авна уу. Энэ жил Монос Хүнс ХК-ийн хувьд түүхэн амжилтаар дүүрэн, үнэ цэнэ бүтээгч хамт олны хүч хөдөлмөрөөр тодорхойлогдсон онцгой жил байлаа. Бид бүтээн байгуулалт, техник, технологийн инновацад бодитой хөрөнгө оруулалт хийж, байгаль орчиндоо хүндэтгэлтэй хандах, үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаа олон улсын стандартад нийцүүлж, нэгдсэн удирдлагын тогтолцоог хэрэгжүүлж ажиллалаа.

2024 онд томоохон төслийг удирдаж хэрэгжүүлэнгээ борлуулалтын орлогоо 20%-иар, цэвэр ашгаа 16%-иар тус тус нэмэгдүүлж, зах зээлд амжилттай өсөлт үзүүлээ. Шинээр Уушги цэвэрлэх "Цэнэг" бэлдмэлийг танилцуулсан нь

агаар орчны бохирдолтой өнөө үед цагаа олсон, хэрэглэгчдийн таашаалд нийцсэн, эрэлттэй бүтээгдэхүүнүүдийн нэг болсон байна.

MFC 2.0 нэгдсэн үйлдвэрийн төсөл бүрэн хэрэгжиж, ашиглалтад орсноор шингэн хүнсний үйлдвэрлэлийг гурав дахин нэмэгдүүлж, хуванцрын агууламж багатай, байгальд ээлтэй савлагаатай Экос усыг хэрэглэгчдэд санал болгоод байна. Энэхүү савлагаагаар хуванцрын хэмжээгээ 30% бууруулж, ердөө гурван сарын хугацаанд 43 тонн хуванцрын хаягдлыг бууруулж чадсан юм.

Бид үйлдвэрлэлийн үйл ажиллагаандаа ISO 9001:2015 (Чанарын удирдлагын тогтолцоо), FSSC 22000:2018 (Хүнсний аюулгүй байдал), ISO 14001:2015 (Байгаль орчны удирдлага) зэрэг олон улсын стандартыг амжилттай нэвтрүүлж, Швейцарын SGS компанийн аудитаар баталгаажууллаа. Энэ нь манай бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн чанар олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөний илэрхийлэл юм.

Манай хамт олны байгаль орчинд ээлтэй, нийгмийн хариуцлагатай үйл ажиллагааг үнэлж, Монголын Хүнсчдийн Холбооноос "Монгол Улсын Хүнсний Манлай Үйлдвэр" хэмээн өргөмжилсөн нь бидний хөдөлмөр, хичээл зүтгэлийн томоохон үнэлгээ боллоо.

Цаашид ч бид оролцогч талуудынхаа итгэл найдварыг хүлээсэн, нийгэмдээ эерэг соёлыг түгээгч, инновацлаг бүтээгдэхүүнээр түүчээлэгч хамт олон байх болно.

ТҮҮХЭН ТОВЧОО

2012

Монос Фарм ХХК-аас өрх тусгаарлаж, Монос Хүнс ХХК албан ёсоор үүсгэн байгуулагдав. Эрүүл мэндийн ус, ундааны цехийг ашиглалтад оруулав.



2013

Шилэн савлагаатай Цэнэг эрүүл мэндийн бэлдмэлийг үйлдвэрлэлд нэвтрүүлэв.



2015

Монгол Улсад анх удаа эрүүл мэндийг дэмжсэн үйлдэлтэй Монголчуудын хооллолтын онцлог дээр тулгуурлан хүчил шүлтийн харьцааг тэнцвэржүүлэх Экос pH8.5 зөөлөн шүлтлэг усыг үйлдвэрлэв.



2014

ODOO ERP /Enterprise Resource Planning/ системийг компанийн үйл ажиллагаанд нэвтрүүлэв.



2016

Монгол Улсад анх удаа уусдаг цайны төрөлд импортийг орлох аньс, нэрс, чацаргана жимстэй өнгө үнэр амт орлуулагч ашиглаагүй Эко уусдаг цайг үйлдвэрлэж эхлэв.




2017

Чанарын удирдлагын тогтолцоо болох ISO9001:2015 болон Хүнсний аюулгүй байдлын HACCP стандартыг нэвтрүүлэх төслийн ажил эхлэв.



2018

Өтгөрүүлсэн Барагшун бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж эхлэв. Монос Хүнс компани биет бус хөрөнгөө үнэлүүлсэн Монголын анхны компани болов.



2019

Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан IPO хийж нээлттэй Хувьцаат Компани болов. Олон улсын чанарын удирдлагын тогтолцоо ISO9001:2015 болон Хүнсний аюулгүй байдлын HACCP стандартуудыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж Олон улсын аудитын SGS компаниар баталгаажуулж гэрчилгээгээ гардан авав.



2020

Хүнсний үйлдвэрийн нэгдсэн удирдлагын тогтолцоо болох ISO22000:2018 болон Хүний нөөцийн менежментийн ISO:30400 стандартыг нэвтрүүлэх төслийг эхлүүлэв. Эрүүл Мэндийн Шингэн хүнсний үйлдвэрийг ашиглалтад оруулан, 8 нэр төрлийн бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэв.



2021

Vitos брэндийн Цэнэг эрүүл мэндийн бэлдмэлийг шинэчлэн зах зээлд амжилттай байршуулав. Мөн тус брэндийн "Shot" 3 нэр төрлийн биологийн идэвхт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн гаргалаа.



2022

"Монос Хүнс" ХК нь Австри улсад төвтэй "TSC" /The chilled Snack Company/ компанийн ОХУ дахь салбар "TSC Food Products Ru" компанитай хамтран ажиллаж Милино брэндийн Творожное Драже үрлийг тус улсын зах зээлд амжилттай гаргалаа. Тус бүтээгдэхүүнийг Киргиз болон Евразийн 5 улсад гаргах боломж бүрдлээ.



2023

Эрүүл мэндийг дэмжигч Монос Хүнс ХК, Монгол эрэгтэйчүүдийн эрүүл мэндэд анхаарал хандуулж "Хэнэгтэй Монгол Эр хүн" төслийг амжилттай эхлүүлж эрэгтэйчүүдийн тухай хэвшмэл ойлголтыг халах, өөрчлөх нийгмийн нөлөөллийн төслийг амжилттай хэрэгжүүлж давхардсан тоогоор 22 сая хүнд хүргэж чадлаа.

Мөн 2023 онд Бүгд Найрамдах Киргиз улсын эм ханган нийлүүлэх Лекарь компаниар дамжуулан 20 нэр төрлийн бүтээгдэхүүнээ албан ёсны эрхтэйгээр тус улсад худалдан борлуулахаар боллоо.



2024

Монос Хүнс ХК 2024 онд MFC 2.0 нэгдсэн үйлдвэрийн төслийг амжилттай хэрэгжүүлж, III улиралд ашиглалтад оруулснаар шингэн хүнсний үйлдвэрлэлийн хүчин чадлаа гурав дахин нэмэгдүүлж, бүтээгдэхүүний хүртээмж, үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүллээ. Бид үйлдвэрлэлийн үйл ажиллагаандаа ISO 9001:2015 (Чанарын удирдлагын тогтолцоо), FSSC 22000:2018 (Хүнсний аюулгүй байдал), ISO 14001:2015 (Байгаль орчны удирдлага) зэрэг олон улсын стандартыг амжилттай нэвтрүүлж, Швейцарын SGS компанийн аудитаар баталгаажууллаа.



МОНОС ХҮНС ХК-ИЙН УДИРДЛАГЫН БАГ



А.ОТГОНДАРЬ
Гүйцэтгэх захирал



Ц.ДЭЛГЭРМАА
Санхүү хариуцсан захирал



Э.АМАРБОЛД
Үйл ажиллагаа
эрхэлсэн захирал



Б.БАЯНЖАРГАЛ
Үйлдвэрлэл хариуцсан
захирал



Б.ХАШ-ЭРДЭНЭ
Экспорт Бизнес Хөгжлийн
Албаны дарга



Н.ЦАГААНХҮҮ
Захиргаа хүний нөөцийн
албаны дарга



С. ЦЭРЭНПИЛ
Хуурай хүнсний
үйлдвэрийн дарга



Б. МӨНХЦЭЦЭГ
Чанар Баталгаажилтын
албаны дарга



Ц.БОЛДЧИМЭГ
Хүний нөөцийн
ахлах менежер



Н.НАРАНБАТ
Борлуулалтын
албаны дарга



С.ГЭРЭЛСҮРЭН
Хангамж аж ахуйн
албаны дарга



Б.ХУЛАНГОО
Чанар хяналтын
лабораторийн албаны дарга



Б.СҮХ-ЭРДЭНЭ
Инженер техникийн
албаны дарга



Ч.СЭЛЭНГЭТУЯА
Ложистикийн албаны дарга



Г. БУЯНДЭЛГЭР
Ерөнхий нягтлан бодогч



П.ЭНХБАЯР
Санхүүгийн менежер



Ц.ДӨЛГӨӨНМАЙДАР
Маркетингийн албаны дарга



БАТАЛГААЖСАН СТАНДАРТУУД



Чанарын
менежментийн
тогтолцоо
ISO 9001:2015



FSC 22000

Хүнсний аюулгүй
байдлын тогтолцоо
FSC 22000



Лабораторийн
ISO 17025



Байгаль орчны
чанарын удирдлагын
тогтолцоо
ISO 14001



2

ЭКСПОРТ



Монос Хүнс ХК нь 2012 оноос эхлэн эрүүл мэндийг дэмжсэн хүнс болон хүнсний нэмэлт бүтээгдэхүүн үйлдвэрлэж, уул уурхайн бус, нэмүү өртөг шингэсэн бараа бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэхээр ажиллаж байна.

БҮГД НАЙРАМДАХ КИРГИЗ УЛС (БНК_{ИР}У)

Бүгд Найрамдах Киргиз Улс нь алслагдмал бүс биш учраас тус зах зээлийг стратегийн ач холбогдолтой гэж үзэн, анхаарал хандуулан ажиллаж байна.

“Монос Хүнс” ХК-д үйлдвэрлэж буй 11 нэр төрлийн Хүнсний нэмэлт бүтээгдэхүүнийг ОХУ-ын “СГР” (Улсын бүртгэлийн гэрчилгээ) гэрчилгээнд хамруулан бүртгүүлэв. Мөн “ЕАС” гэрчилгээнд хамруулснаар Орос, Беларусь, Казахстан, Армен, Киргиз зэрэг орнуудад борлуулах хүчинтэй бөгөөд тухайн зах зээлд бүтээгдэхүүнээ нэвтрүүлэх боломжтой болоод байна.

2024 оны нэгдүгээр улиралд дотооддоо үйлдвэрлэсэн 20 нэр төрлийн бараа бүтээгдэхүүнийг «Лекарь» ХХК-ийн захиалгаар амжилттай экспортлов. Улмаар 2024 оны 4-р сарын 16-ны өдөр тус улсад бүтээгдэхүүнээ худалдаалах албан ёсны нээлтийн арга хэмжээг зохион байгуулсан юм.

2024 оны хоёрдугаар улиралд дахин захиалга хүлээн авч, гуравдугаар улиралд бараа бүтээгдэхүүнээ нийлүүлэв.



2024 оны дөрөвдүгээр улиралд Евроазийн зах зээл дэх экспортын хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор Бүгд Найрамдах Кыргызстан Улсын «Монос Кей Джи» дистрибьютерийн компанитай **28 нэр төрлийн бараа бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ байгуулсан.**

Ийнхүү Монос Хүнс ХК нь Бүгд Найрамдах Кыргызстан Улсад бүтээгдэхүүнээ тогтвортой нийлүүлж, зах зээлээ тэлэх чиглэлээр амжилттай ажиллаж байна.



3

САНХҮҮГИЙН
ТАЙЛАН



САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН 2024

Үзүүлэлт /сая.төг/	2023 он Аудитлагдсан	2024 он Аудитлагдсан	Өөрчлөлт %	Нийт хөрөнгөд эзлэх %	
				2023 он	2024 он
ХӨРӨНГӨ	77,336.5	58,988.4	-24%	100%	100%
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	27,537.5	2,292.4	-92%	36%	4%
Дансны авлага	3,956.9	5,196.9	31%	5%	9%
НДШ - ийн авлага	2,174.9	43.7	-98%	3%	0%
Бусад авлага	155.9	300.5	93%	0%	1%
Бараа материал	4,944.9	7,806.7	58%	6%	13%
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	393.1	500.7	27%	1%	1%
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө	0.0	1,428.8	-	0%	2%
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	39,163.2	17,569.7	-55%	51%	30%
Үндсэн хөрөнгө	37,399.9	38,045.0	2%	48%	64%
Биет бус хөрөнгө	414.0	327.1	-21%	1%	1%
Хойшлогдсон татварын хөрөнгө	76.1	95.2	25%	0%	0%
Бусад эргэлтийн бус хөрөнгө	283.2	2,951.4	942%	0%	5%
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ	38,173.3	41,418.7	9%	49%	70%

САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН 2024

Үзүүлэлт /сая.төг/	2023 он Аудитлагдсан	2024 он Аудитлагдсан	Өөрчлөлт %	Нийт хөрөнгөд эзлэх %	
				2023 он	2024 он
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	77,336.5	58,988.4	-24%	100%	100%
ӨР ТӨЛБӨР	55,330.3	35,434.9	-36%	72%	60%
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	19,484.5	19,392.9	0%	25%	33%
Дансны өглөг	1,079.6	1,621.1	50%	1%	3%
Цалингийн өглөг	164.5	605.0	268%	0%	1%
Татварын өр	1,688.1	866.6	-49%	2%	1%
НДШ-ийн өглөг	151.5	84.4	-44%	0%	0%
Богино хугацаат зээл	15,184.9	14,625.1	-4%	20%	25%
Зээлийн хүүгийн өглөг	249.5	32.4	-87%	0%	0%
Урьдчилж орсон орлого	48.5	93.7	93%	0%	0%
Нөөц өр төлбөр	211.0	231.0	9%	0%	0%
Бусад богино хугацаат өр төлбөр	706.9	1,233.8	75%	1%	2%
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	35,845.8	16,042.0	-55%	46%	27%
Урт хугацаат зээл	29,025.6	13,507.4	-53%	38%	23%
Нөөц өр төлбөр	6,449.5	2,467.6	-62%	8%	4%
Хойшлогдсон татварын өр	213.5	0.0	-100%	0%	0%
Бусад урт хугацаат өр төлбөр	157.2	67.0	-57%	0%	0%
ЭЗДИЙН ӨМЧ	22,006.2	23,553.5	7%	28%	40%
Өмч - Хувьцаат	2,318.2	2,318.2	0%	3%	4%
Нэмж төлөгдсөн капитал	6,835.7	6,835.7	0%	9%	12%
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	2,508.1	0.0	-100%	3%	0%
Хуримтлагдсан ашиг	10,344.2	14,399.6	39%	13%	24%

ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН




Үзүүлэлт /сая.төг/	2023 он Аудитлагдсан	2024 он Аудитлагдсан	Өөрчлөлт %
Борлуулалтын орлого (цэвэр)	31,676.9	37,993.3	20%
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	17,203.8	19,715.0	15%
НИЙТ АШИГ (АЛДАГДАЛ)	14,473.1	18,278.2	26%
Хүүний орлого	11.0	150.5	1265%
Бусад орлого	35.5	66.1	86%
Борлуулалт, маркетингийн зардал	6,711.2	8,303.2	24%
Ерөнхий ба удирдлагын зардал	3,029.5	4,312.9	42%
Санхүүгийн зардал	635.7	1,022.9	61%
Бусад зардал	207.9	273.3	31%
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-18.1	-37.2	106%
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.0	17.2	
ТАТВАР ТӨЛӨХИЙН ӨМНӨХ АШИГ (АЛДАГДАЛ)	3,917.4	4,562.5	16%
Орлогын албан татвар	437.1	511.8	20%
ТАЙЛАНТ ҮЕИЙН ЦЭВЭР АШИГ (АЛДАГДАЛ)	3,480.3	4,050.7	16%

САНХҮҮГИЙН ХАРЬЦАА ҮЗҮҮЛЭЛТҮҮД




Үзүүлэлт	2023 он	2024 он
I. ТӨЛБӨРИЙН ЧАДВАРЫН ШИНЖИЛГЭЭ / LIQUIDITY RATIOS		
Эргэлтийн харьцаа / Current Ratio	2.0	0.9
Түргэн хөрвөх харьцаа / Quick Ratio	1.8	0.5
II. САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ШИНЖИЛГЭЭ / LEVERAGE RATIOS		
Бие даалтын коэффициент / Shareholder Equity ratio	28%	40%
Өрийн харьцаа / Debt ratio	72%	60%
Өр эзний өмчийн харьцаа / Debt-to-Equity	251%	150%
Хөшүүргийн харьцаа / Debt-to-EBITDA	7.97	3.93
III. АШИГТ АЖИЛЛАГААНЫ ШИНЖИЛГЭЭ / PROFITABILITY RATIOS		
Нийт ашгийн хувь / Gross profit margin	44.4%	45.7%
ХТЭХӨАшгийн хувь / EBITDA margin	17.5%	18.8%
Цэвэр ашгийн хувь / Net income margin	11.0%	10.7%
Нийт хөрөнгийн өгөөж / Return on Assets - ROA	4.5%	6.9%
Өөрийн хөрөнгийн өгөөж / Return on Equity - ROE	15.8%	17.2%

ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Жилээр




Улирлаар



ХУВЬЦААНЫ МЭДЭЭЛЭЛ


Тайлант хугацаанд хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжаагаар 317.52 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 940.75 сая ширхэг хувьцаа арилжсанаас Монос Хүнс ХК **11,479,493 ширхэг хувьцааг арилжиж, хувьцааны идэвхээр 16-д эрэмбэлэгдэж байна.**



ТАТВАР, ДААТГАЛЫН МЭДЭЭЛЭЛ

Монос Хүнс ХК нь 2024 онд нийт **8 тэрбум төгрөгийн татвар, даатгал, НДШ** төлсөн бөгөөд үүнээс 5.6 тэрбум төгрөг нь татварт, 2.3 тэрбум төгрөг нь эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлд төлөгджээ.

Монос Хүнс ХК-ийн татварын болон нийгмийн хариуцлагын үүргээ нэр төртэй биелүүлж байгааг харуулж байгаа улс орны эдийн засагт оруулж буй бодит хувь нэмэр юм.



4

ҮЙЛ ЯВДЛЫН ТОЙМ

2024 ОНЫ ҮЙЛ ЯВДЛЫН ТОЙМ



“Цэнэг” брэндийн Уушги цэвэрлэх шинэ бүтээгдэхүүн худалдаанд гарлаа

“Цэнэг” брэнд бүтээгдэхүүнийхээ хүрээг тэлж, Уушги цэвэрлэх бэлдмэлээ зах зээлд танилцууллаа. Агаарын бохирдол, тоос тоосонцортой орчинд ажиллаж, амьдардаг хүмүүсийн хэрэгцээнд нийцүүлэн бүтээгдсэн энэхүү бэлдмэл нь гүргэм, чихэр өвсний хуурай ханд, говийн ганга өвс, чацарганы хатаасан үр, хальс зэрэг байгалийн гаралтай найрлагыг агуулснаараа онцлог юм.



MFC 2.0 төсөл амжилттай хэрэгжиж, үйлдвэрийн хүчин чадал гурав дахин нэмэгдлээ

2024 онд бид MFC 2.0 нэгдсэн үйлдвэрийн төслийг амжилттай хэрэгжүүлж, шингэн хүнсний үйлдвэрлэлийн хүчин чадлаа гурав дахин нэмэгдүүллээ. Шинэ үйлдвэртээ дэвшилтэт техник, технологи нэвтрүүлснээр “Экос” эрүүл мэндийн усны хуванцрын хэрэглээг 30%-иар бууруулж, 43 тонн хуванцар хаягдлаас сэргийллээ.



Экспортын цар хүрээгээ тэллээ

БНКирУ дахь Монос Кей Джи ХХК-тай Дистрибьютерийн гэрээ байгуулж, тухайн зах зээлд 28 нэр төрлийн бүтээгдэхүүнүүд борлуулж эхлээд байна.

2024 ОНЫ ҮЙЛ ЯВДЛЫН ТОЙМ



Үйлдвэрлэлийн чанараа олон улсад баталгаажууллаа

Бид үйлдвэрлэлийн үйл ажиллагаандаа ISO 9001:2015 (Чанарын менежмент), FSSC 22000:2018 (Хүнсний аюулгүй байдал), ISO 14001:2015 (Байгаль орчны менежмент) зэрэг олон улсын стандартыг амжилттай нэвтрүүлж, Швейцарын SGS компанийн аудитаар баталгаажууллаа. Энэ нь манай бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн чанар олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөний илэрхийлэл боллоо.



ТУЗ-ийн гишүүд шинэчлэгдлээ

Монос Хүнс ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл шинэчлэгдэж, 5 хараат бус гишүүнтэй боллоо. Энэ нь компанийн засаглал, шийдвэр гаргалтын ил тод байдал, хараат бус хяналтыг сайжруулж, бизнесийн тогтвортой өсөлтийг хангахад чухал ач холбогдолтой юм.



“Монгол Улсын Хүнсний Манлай Үйлдвэр – 2025”

Хүнсний салбарт оруулсан бидний хүчин чармайлт өндрөөр үнэлэгдэж, “Монгол Улсын Хүнсний Манлай Үйлдвэр” шагналыг хүртсэнээр 2024 оныг бахдам амжилтаар үдсэн юм.

5

2024 ОНЫ ТУЗ-ИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГАА

ТУЗ-ИЙН ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ



Монос Хүнс ХК-ийн ТУЗ-ийн дарга, Монос Группийн гүйцэтгэх захирал

Х. АНАНД

Эрүүл мэндийн хүнсний үйлдвэрлэлд тэргүүлэгч Монос Хүнс ХК-ийн эрхэм хэрэглэгчид, 14 мянга гаруй хувьцаа эзэмшигч та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Нийгэм, эдийн засгийн олон сорилтуудын дунд, үйл ажиллагааны чиг баримжаа, алсын хараа, эрхэм зорилгоосоо хазайлгүйгээр хэрэглэгчдийнхээ эрүүл мэнд, урьдчилан сэргийлэх үйлсэд хувь нэмрээ оруулж буй Монос Хүнс ХК нь 2024 онд бүтээн байгуулалтын олон амжилттай ажилласан бөгөөд үүнийгээ танилцуулахад таатай байна.

Монос Хүнс ХК нь 24 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт бүхий MFC 2.0 нэгдсэн үйлдвэрийн төслөө амжилттай ашиглалтад оруулаад байна. Ингэснээр Монос Хүнс ХК-ийн үйлдвэрлэлийн хүчин чадал гурав дахин нэмэгдэж,

эрүүл мэндийн хүнсээ хэрэглэгчдэдээ илүү хүртээмжтэй хүргэх боломжийг бүрдүүлжээ. Энэ нь анхдагч зах зээлд хувьцаагаа байршуулж, олон нийтэд нээлттэй компани болсноосоо хойш хоёр дах том бүтээн байгуулалтын төсөл юм.

Үйл ажиллагаа, хүчин чадал нэмэгдэхийн хэрээр экспортын борлуулалтаа тэлэхэд анхаарч, Төв Азийн орнуудад бүтээгдэхүүнээ бүртгэлжүүлж, эхний байдлаар Киргиз Улсад 6 брэндийн 28 нэр төрлийн бүтээгдэхүүнийг нийлүүлж эхлээд байна.

Түүнчлэн, засаглалын ил тод байдал, хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг, компанийн тогтвортой хөгжлийг хангах зорилгоор ТУЗ-ийн бүтцийг шинэчилж, хараат бус гишүүдийн тоог хоёроор нэмэгдүүлж, ТУЗ-ийн доор 3 хороодоор дамжуулж засаглалын хяналтыг хэрэгжүүлж байсныг 4 болгон нэмэгдүүллээ.

ТУЗ-өөс Гүйцэтгэх удирдлагын Тогтвортой Хөгжлийн Бодлогод хувь нэмрээ оруулах, байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэл явуулахад чиглэсэн санаачилгыг бүрэн дэмжин ажиллаж байна.

Бидний хичээл зүтгэлийг үргэлж дэмжин, эрүүл, чанартай бүтээгдэхүүнийг сонгон хэрэглэдэг эрхэм хэрэглэгчид, итгэлтэй харилцагч, хувьцаа эзэмшигч та бүхэндээ чин сэтгэлийн талархал илэрхийлье.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ



Х.АНАНД

ТУЗ-ИЙН ДАРГА

Монос Групп Гүйцэтгэх захирал
ТУЗ-ийн дэргэдэх ЦУХ-ны дарга



Л.ХҮРЭЛБААТАР

ТУЗ-ИЙН ГИШҮҮН

Монос Группийн үүсгэн
байгуулагч, Монгол Улсын
Хөдөлмөрийн баатар, Академич



А.ОТГОНДАРЬ

ТУЗ-ИЙН ГИШҮҮН

Монос Хүнс ХК-ийн
Гүйцэтгэх захирал



Х.СОЛОНГО

ТУЗ-ИЙН ГИШҮҮН

Монос Групп Үйл ажиллагаа
эрхэлсэн захирал



Ч.БАТТОГТОХ

ТУЗ-ИЙН ГИШҮҮН

АШУИС-ийн
тэнхимийн эрхлэгч



Ц.ЦЭЦЭГБАДАМ

ТУЗ-ИЙН ГИШҮҮН

Монос Групп Санхүү
эрхэлсэн захирал



Г.ЗОЛЖАРГАЛ

ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН

Ашид Ассет менежмент
ҮЦК ХХК Үйл ажиллагаа
хариуцсан захирал,
ТУЗ-ийн дэргэдэх АЭХ-ны дарга



М.САРАНДАВАА

ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН

Повер солюшн ХХК
Гүйцэтгэх захирал



Д.ЭНХЖАРГАЛ

ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН

Судлаач
ТУЗ-ийн дэргэдэх НДХ-ны дарга



Д.ГЭРЭЛТ-ОД

ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН

Контент Маркетинг ХХК
Гүйцэтгэх захирал,
ТУЗ-ийн дэргэдэх СБХХ-ны дарга



Н.УЛААНХҮҮ

ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН

Эдийн засагч

МОНОС ХҮНС ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

ТУЗ-ийн бүрэлдэхүүн

2024-01-01 өдрөөс 2024-09-09 өдрийг хүртэл ТУЗ 9 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр, 2024-09-09 өдөр хуралдсан Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын өдрөөс хойш ТУЗ 11 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр ажилласан.

2024-09-09-ний өдөр хуралдсан Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар нийт 20 нэр дэвшигчээс 6 ердийн, 5 хараат бус нийт 11 гишүүнийг томилов.

ТУЗ-ийн хурлын үйл ажиллагаа

2024 онд ТУЗ нийт 10 удаа танхим, цахим, эчнээ санал хураалтын хэлбэрээр хуралдсанаас ээлжит хурал 4, ээлжит бус хурал 6 удаа хуралдаж, нийт 17 тогтоол гаргасан.

ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД

2024 оны 4-р сарын 20-ны өдөр болсон Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 03 тоот тогтоолоор ТУЗ-ийн дэргэдэх хороодыг 4 болгон шинэчилжээ.

- Цалин, урамшууллын хороо
- Нэр дэвшүүлэх хороо
- Аудит, эрсдэлийн хороо
- Стратеги, бизнес хөгжлийн хороо



ТУЗ-ИЙН ХУРЛААС 2024 ОНД ДАРААХ ШИЙДВЭРҮҮДИЙГ ГАРГААД БАЙНА.

• 2024 оны 1-р улиралд хуралдсан хурлаар компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, хөндлөнгийн аудитын дүгнэлт, ногдол ашиг хуваарилах асуудал, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэсэн.

• 2024 оны 2-р улиралд хуралдсан хурлаар компанийн үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой асуудлыг авч хэлэлцэн, хууль, дүрэмд зааснаар саналын эрхтэй гишүүдийн шийдвэрээр асуудлыг шийдвэрлэсэн.

• 2024 оны 3-р улиралд хуралдсан хурлаар компанийн эхний хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайлан, 2024 оны төсвийн тодотгол, ТУЗ гишүүдийг сонгох асуудлыг хэлэлцэх хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэсэн.

• 2024 оны 4-р улиралд шинээр сонгогдсон ТУЗ анхны хурлаа хийж, ТУЗ-ийн дарга, дэргэдэх хороодын дарга, нарийн бичгийн дарга нарыг томилсон, мөн ээлжит хурлаар компанийн 2024 оны 3-р улирлын тайлан, 2025 оны зорилт, төсвийг болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн байна.

ТУЗ нь компанийн засаглал, удирдлагын хяналтыг сайжруулж, хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах бодлогоо тууштай хэрэгжүүлж байна.



6

ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛ

(БОНЗ)-ЫН 2024 ОНД ХИЙГДСЭН АЖЛУУД

Монос Хүнс ХК 2024 онд байгаль орчин, нийгмийн засаглал (БОНЗ)-ын бодлогоо өргөжүүлж, тогтвортой хөгжлийг дэмжсэн хэд хэдэн томоохон ажлуудыг амжилттай хэрэгжүүллээ.

БАЙГАЛЬД ЭЭЛТЭЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

MFC 2.0 нэгдсэн үйлдвэрийн төслийг амжилттай хэрэгжүүлснээр “Экос” усны хуванцрын хэрэглээг **30%-иар бууруулж, 43 тонн хуванцар хаягдлаас сэргийлээд байна.** Мөн “Энхжин” цайны савлагааг шинэчилж, хуванцрын хэрэглээг **90%, цаасны хэрэглээг 30%-иар бууруулснаар жилд 8 тонн хог хаягдлаас сэргийллээ.**

Байгаль орчинд ээлтэй “нимгэн савлагаатай” бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, нөөцийн зохистой хэрэглээг дэмжив.

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА БА АЖИЛТНУУДЫН ХӨГЖИЛ

2024 онд шинээр **22 ажлын байр бий болгож, нийт 260 гаруй ажилтныг** өндөр ур чадвартай баг бүрдүүлэх зорилгоор сургалт, хөгжлийн хөтөлбөрт хамруулсан.

Монос Хүнс ХК нэн тэргүүнд ажилчдын эрүүл мэнд, аюулгүй байдалд анхаарч ажилладаг төдийгүй энэ чиглэлээр ажлын орчин нөхцөлийг тасралтгүй сайжруулан ажиллаж байна.



ОЛОН УЛСЫН СТАНДАРТ, ХАРИУЦЛАГАТАЙ БИЗНЕС

Байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах зорилгоор **ISO 14001** (Байгаль орчны менежмент), **ISO 9001** (Чанарын менежмент), **FSSC 22000** (Хүнсний аюулгүй байдал), **ISO 17025** (Лабораторийн чадавх) зэрэг олон улсын стандартуудыг амжилттай нэвтрүүлж, Швейцарын **SGS** байгууллагаар баталгаажууллаа.

Ногоон санхүүжилт, тогтвортой хөгжлийн зарчмуудыг бизнесийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх бодлогыг баримталж байна.

ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТ БА УСНЫ ЗОХИСТОЙ ХЭРЭГЛЭЭ

Нарны эрчим хүчний хэрэглээг орчны гэрэлтүүлэг хэсэгт шийдэж, эрчим хүчний хэрэглээг хэмнэх, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах боломжийг нэмэгдүүлсэн.

Саарал усны хэрэглээг ахуйн хэрэглээ, цэвэрлэгээ үйлчилгээ болон компанийн гаднах ногоон байгууламжийн арчилгаа, усалгаанд ашиглаж, цэвэр усны хэрэглээг бууруулах чиглэлээр ажиллалаа.

2024 онд бид байгальд ээлтэй, нийгэмдээ хариуцлагатай, засаглалын ил тод байдлыг эрхэмлэсэн компанийн хувьд тууштай ажиллаж, цаашид энэхүү бодлогоо улам өргөжүүлэн, тогтвортой хөгжлийг тэргүүн зорилгоо болгож ажиллах болно.



ТӨВ ОФФИС:

Сонсголонгийн зам гудамж 32/3 тоот,
Үйлдвэрийн баруун бүс, БГД, 20-р хороо,
Улаанбаатар, 16103, Монгол Улс

МАРКЕТИНГ, БОРЛУУЛАЛТЫН АЛБА:

Эко Интернэйшнл тауэр 19 давхар 1908
тоот, СБД, Нэгдүгээр хороо, Улаанбаатар,
Монгол Улс



www.monosfoods.mn



Foods@monos.mn



MonosFoods



976-7777-3525